

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН 2020-2024 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ
ХӨТӨЛБӨРИЙН 2024 ОНЫ 01, 02 ДУГААР САРЫН ХЭРЭГЖИЛТЭД ХИЙСЭН
ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ТАЙЛАН

2024 оны 03 дугаар сарын 04

Улаанбаатар хот

Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрөөс 2024 оны 01, 02 дугаар сарын байдлаар байгууллагын үйл ажиллагаатай холбоотой 1 зорилтын 1 арга хэмжээний хэрэгжилтэд Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор баталсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ын дагуу хяналт-шинжилгээ хийж, үр дүнг дараах байдлаар үнэлэв. Үүнд:

Арга хэмжээ: Гадаадын иргэн, харьяалалгүй хүний бүртгэл, мэдээлэл, хяналтын тогтолцоог боловсронгуй болгоно” зорилтод тусгагдсан “Гадаадын иргэн, харьяалалгүй хүний биеийн давхцахгүй өгөгдөл бүхий бүртгэлийн системийг үе шаттайгаар нэвтрүүлнэ.

Хэрэгжилт: “Гадаадын иргэний виз, бүртгэл, мэдээллийн нэгдсэн сан” isf.mn системд нэмэлт хөгжүүлэлтийг тогтмол хийж, хэвийн ажиллагааг ханган визийн зөвшөөрөл, виз, оршин суух зөвшөөрөл, гадаадын иргэний бүртгэл хэсгийн 4537 хүсэлтийг тайлант хугацаанд тус системээр хүлээн авч шийдвэрлэсэн. 2024 оны 01, 02 дугаар сарын гүйцэтгэлээр хөгжүүлэлтэд байгууллагаас төсөв зарцуулаагүй.

Энэхүү арга хэмжээ нь тавьсан зорилтдоо бүрэн хүрээгүй боловч зохион байгуулалтын арга хэмжээ бүрэн авагдсан, холбогдох байгууллагын шийдвэр гарсан, гол үр дүн гарч эхэлж байгаа тул хэрэгжилт 90 хувийн биелэлттэй үнэлэгдлээ.

Дээрх арга хэмжээний хүрээнд “Гадаадын иргэний виз, бүртгэл, мэдээллийн нэгдсэн сан” (ISF) системийн үйл ажиллагааны хэрэгжилт, үр дүнг бууруулахгүйгээр бүрэн хангаж, хэвийн явагддаг болсон байхад анхаарч, хөгжүүлэлтийг тогтмол хийж сайжруулах шаардлагатай.

--oo0oo--